**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 06 дугаар сарын 21 Мандалговь хот

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт хүрээгүй бол тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ: ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР /ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | |
| 1 | “Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулж, УИХ-аар батлуулах ажлын хүрээнд орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулах | - | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо<br><br>Хэлэлцүүлэгт хамрагдсан иргэдийн тоо | 1<br>- | 1 | “Монгол Улсын Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн танилцуулга, хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Барилгын хөгжлийн төвийн Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтэстэй хамран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын орлогч болон аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, холбогдох хэлтэс агентлагийн дарга, албан хаагчид зэрэг нийт 58 гаруй хүн оролцож, санал солилцож уг төслийг дэмжсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | 1. Аймаг, сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж инженерийн дэд бүтцийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх:<br>2. Хот байгуулалтын кадастрын цахим системээр иргэд, аж ахуй нэгжид тогтмол үйлчилгээ үзүүлэх, системийн ашиглалтын талаар нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтын талаар санал гаргаж газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | - | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд орсон сумын тоо<br><br>Нэмэлт хөгжүүлэлт хийлгэхээр хүргүүлсэн саналын тоо | 14<br>- | 1<br><br>2 | 2022 онд Орон нутгийн төсвийн 150,0 сая төгрөгөөр “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд 14 сумын төвийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулсан. 2023 онд аймгийн төвийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг Хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажил хийгдэнэ.<br>Хот байгуулалтын кадастрын цахим системийн ашиглалт нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтын талаар саналыг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр ГЗБГЗЗГ-т urban.gov.mn@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Бүсийн тулгуур төвүүдийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тайлагнах | - | Төлөвлөгөө боловсруулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар Баянжаргалан, Өндөршил, Луус, Хулд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг болон “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцэж хүлээн авсан бөгөөд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 4 | Газрын багц хууль, Геодези зураг зүйн тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулах ажлын хүрээнд орон нутагт олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэж ажлын хэсэгт хүргүүлэх. | - | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо<br><br>Хэлэлцүүлэгт хамрагдсан иргэдийн тоо | - | 1<br><br>50 | Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын багц хуулийн төсөл болох Газрын ерөнхий хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Кадастрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Хот байгуулалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр аймгийн удирдлагууд болон төрийн байгууллага, иргэд олон нийтийн дунд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 47 иргэн оролцсон ба оролцогчдоос болон албан хаагчдаас ирүүлсэн 59 саналыг нэгтгэж тайланг ГХБХБГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 2/28 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт: 100 хувь** |
| 5 | Аймгийн ерөнхий архитекторын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын үр дүнг бүтэн жилээр үнэлэн ГЗБГЗЗГ болон БХБЯ-нд хүргүүлэх | - | Архитекторын тайлангийн гүйцэтгэлийн хувь | 84,75 | 85 | Аймгийн Ерөнхий архитекторын 2022 оны үйл ажиллагааны тайланг хянаж, баталгаажуулан ГХБХБГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 3/23 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Тайлангийн үнэлгээ ирээгүй болно. **Хэрэгжилт: ХБ** |
| 6 | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд заасан хувь хэмжээгээр аймаг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, мод үржүүлгийн зориулалтаар газар эзэмшүүлэх ажлыг дэмжиж ажиллах” арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх | - | Тохижилт, цэцэрлэгжүүлэлт хийсэн газрын хэмжээ /га/ | - | 60 га | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зориулалтаар 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 21 байршилд 471,13 га газрыг төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд 40 га газарт ногоон байгууламж, мод тарьсан. **Хэрэгжилт: 66.6 хувь** |
| **ХОЁР: ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 7 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | - | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн тоо | 2 | 2 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2019-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж аймгийн Засаг даргаар батлуулсан. 2023 оны хагас жилийн байдлаар 15 сумын суурьшлын бүс буюу тэг гортигийг шинэчлэн тогтоох ажлыг 2023 оны 06 дугаар сарын 27-ны аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт: 50 хувь** |
| 8 | 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын талаар гарсан Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | - | Иргэдээс ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Дундговь аймагт 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 105 дугаар тогтоолоор батлагдсан.<br>Иргэдээс өмчлөлийн газрын өргөдлийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн авсан ба 63 иргэнээс газар өмчлөх тухай хүсэлт ирж, 3 иргэнд 0,19 га газрыг өмчлүүлээд байна.<br>Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн 2/204 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>**Хэрэгжилт: ХБ** |
| 9 | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааны судалгааг гаргаж шийдвэрлэх саналын хамт ирүүлэх, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хилийн цэсийн маргаан шийдвэрлэх ажлыг хамтран зохион байгуулах. | - | Хилийн цэсийн маргааны шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Хилийн цэсийн маргаан болон харьяалах нутаг дэвсгэрийн хилийн гадна иргэн хуулийн этгээдэд газар эзэмших, өмчлөх, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын зааврын дагуу зөрчилтэй олгосон 6 сумын 31 нэгж талбарыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж 13 газрын зөрчлийг арилгаж харьяа сумын Засаг даргаар захирамж гаргуулан зөрчлийг арилгасан. Тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 2/205 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хэрэгжилт: 41.9 хувь** |
| 10 | Газрын тухай хуулийн дагуу газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулах | - | Сумдаас тусгай хэрэгцээнд авах газрын санал ирүүлсэн эсэх /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Сумдаас газрыг улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авах санал ирээгүй байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 11 | Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, шилжүүлэх, цуцлах болон тэдгээрийг улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд бүртгэх ажлыг Газрын кадастрын нэгдсэн цахим системээр дамжуулан шийдвэрлэх | - | Газрын кадастрын цахим системээр дамжуулан шийдвэрлэсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Газрын кадастрын цахим системд иргэн, аж ахуй нэгж байгууллагаас цахимаар 165 өргөдөл хүсэлт ирүүлснийг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, иргэдэд хариуг хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 12 | Төрийн өмчийн газрын хариуцагчтай гэрээ байгуулж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах | - | Хариуцагчтай гэрээ байгуулсан эсэх /тийм-1, үгүй-0/ | - | 1 | ГЗБГЗЗГ-аас чиглэл ирүүлээгүй байна. **Хэрэгжилт: ХБ** |
| 13 | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааг Газрын биржийн цахим системээр дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулах. | - | Цахимаар зохион байгуулсан дуудлага худалдааны тоо | 78 | 50 | Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар олгохоор тусгагдсан 22 байршилд **23 удаа** дуудлага худалдааг цахимаар зохион байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд 8 байршилд салхин сэнсний судалгааны талбайн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж байна.<br>Газрын дуудлага худалдаа, газрын суурь үнийн орлого 170 сая төгрөгийг орон нутгийн орлогод |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвлөрүүлэхээс газрын дуудлага худалдаанаас 9.0 сая төгрөг, газрын суурь үнэ 97,5 сая төгрөг, нийт **106,5 сая төгрөг**ийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. **Хэрэгжилт: 46 хувь** |
| 14 | Газрын биржийн цахим системээр дамжуулан газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах. | - | Цуглуулсан үнийн мэдээний тоо | 317 | 150 | Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээний худалдагдсан үнийг газар эзэмших, өмчлөх эрх шилжсэн тоогоор, санал болгож буй үнийг зарын дагуу судлан тухай бүр цахим биржид бүртгэж байна. 2023 оны хагас жилийн байдлаар Сайнцагаан 48, Эрдэнэдалай 4, Сайхан-Овоо 1 **нийт 83 үнийн мэдээ**г цахим биржид бүртгэсэн байна. **Хэрэгжилт: 55,3 хувь** |
| 15 | Зөвшөөрөлгүй газар ашиглалтын зөрчлийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | - | Зөрчил арилгасан нэгж талбарын тоо | 67 | 10 | Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 “Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт дур мэдэн өөрийн өмчлөлийн газрын хэмжээг сунгаж хашаажсан 80 иргэнд “Газар чөлөөлөх тухай” хугацаатай “Мэдэгдэх хуудас”-ыг хүргүүлсэн.<br>Мэдэгдэлд заасан хугацаанд газар чөлөөлөөгүй тохиолдолд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх заалтын дагуу албадан чөлөөлөх арга хэмжээ авч, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулах болно. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 16 | Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна олгосон иргэн, хуулийн этгээдийн газрыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. | - | Хилийн гадна олгосон нэгж талбарын зөрчил арилгасан тоо | 18 | 22 | Хилийн цэсийн маргаан болон харьяалах нутаг дэвсгэрийн хилийн гадна иргэн хуулийн этгээдэд газар эзэмших, өмчлөх, ашиглах эрх олгосон зөрчлийг арилгах ажлын зааврын дагуу зөрчилтэй олгосон 6 сумын 31 нэгж талбарыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж 13 газрын зөрчлийг арилгаж харьяа сумын Засаг даргаар захирамж гаргуулан зөрчлийг арилгасан. Тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 2/205 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 17 | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон нийт нэгж талбарт газрын төлбөр, татварыг Газрын төлбөр, татварын нэгдсэн цахим системээр дамжуулан бүрэн ногдуулах ажлыг зохион байгуулах | - | Газрын төлбөр ногдуулсан нэгж талбарын тоо | 6838 | 7200 | 2023 онд аймгийн хэмжээнд нийт 7491 нэгж талбарын ногдуулалтыг үүсгэж, **7241 нэгж талбарын нэхэмжлэл**ийг үүсгээд байна. Татвар төлөгчөөр бүртгэгдээгүй, газар эзэмшигч нас барсан, регистрийн дугаар зөрүүтэй, ТИН дугаар бүртгэлгүй зэрэг шалтгааны улмаас 250 нэгж талбарын нэхэмжлэл үүсээгүй байна. 2023 онд газрын төлбөрийн орлого 517,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар **298,2 сая төгрөг**ийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 18 | Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах | - | Мэдээллийн санд бүртгэсэн сумын тоо | 14 | 1 | 2023 онд "Дундговь аймгийн Сайнцагаан сумын хэмжээнд хот байгуулалтын кадастрын өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж мэдээллийн санд бүртгэх" зөвлөх үйлчилгээний тендерийг Орон нутгийн өмчийн газраас зарласан. **Хэрэгжилт: ХБ** |
| | | | Тавьсан хяналтын тоо | 28 | 2 | |
| 19 | 1. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Монгол хэлний тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хаягийн зураг, хаягийн мэдээллийн санг нэгдсэн системд тогтмол шинэчлэх тогтолцоог бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, уг ажлын хүрээнд гарах төсөв, зардлыг 2023, 2024 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах<br>2. БХБ-ын сайдын 2020 оны 15 дугаар тушаалаар баталсан "Гудамж, | - | Шинээр нэмэгдсэн нэгж талбарын тоо | 204 | 100 | Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэх, засварлах ажил хийгдэж дууссан ба иргэн, аж аж ахуй нэгж, байгууллагын мэдээг хаягийн мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан газрын кадастрын мэдээллийн санд 136 иргэн, 45 аж ахуй нэгж, 23 байгууллагын хаягийг баталгаажуулаад байна.<br>2018 онд аймгийн төвийн Аривжих, Боржигон, Нарлаг, Айраг, Мандал хорооллын 2694 хашааг стандартын дагуу шинээр хаягжуулсан. Үүнээс хойш Дэвжих хороолол болон шинээр нэмэгдсэн гудамж, барилга, хашааг хаягжуулахаар 490 хаягийн тэмдгийг сумын ОНХС-ийн 8.462.000 төгрөгийн хөрөнгөөр хийлгүүлэн хүлээн авсан. **Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2023 он/"-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах. | | | | | |
| 20 | Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллах | - | Хянан баталгааны дүгнэлтийн тоо | 57 | 50 | Газрын мониторингийн цахим системээр **22** нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг хүлээн авч баталгаажуулсан. **Хэрэгжилт: 44 хувь** |
| 21 | Бэлчээрийн газрын өөрчлөлт, доройтлыг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж бэлчээрийн төлөв байдал, даацыг тодорхойлж, бэлчээрийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах. | - | фото мониторингийн аргаар үнэлгээ хийсэн цэгийн тоо | 233 | 233 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг 08 дугаар сард зохион байгуулна. **Хэрэгжилт: ХБ** |
| 22 | Харьяалах нутаг дэвсгэрт хамаарах Геодезийн байнгын цэг тэмдэгт, байр зүйн зураг, хаяг, барилга, өндөржилт, газарзүйн нэр, газар ашиглалт, газрын бүрхэвч, нэгж талбар, инженерийн дэд бүтцийн орон зайн өгөгдлийг Геопортал цахим системд шинэчлэн бүртгэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах | - | Геопортал цахим системд шинэчлэн бүртгэсэн сумын тоо | 14 | 1 | 2023 онд "Дундговь аймгийн Сайнцагаан сумын хэмжээнд хот байгуулалтын кадастрын өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж мэдээллийн санд бүртгэх" зөвлөх үйлчилгээний тендерийг Орон нутгийн өмчийн газраас зарласан. Тус зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд геодезийн байнгын цэг тэмдэгт, байр зүйн зураг, хаяг, барилга, өндөржилт, газарзүйн нэр, газар ашиглалт, газрын бүрхэвч, нэгж талбар, инженерийн дэд бүтцийн орон зайн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгөгдлийг Геопортал цахим системд шинэчлэн бүртгэх ажлыг зохион байгуулна. **Хэрэгжилт: ХБ** |
| **ГУРАВ: ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 23 | Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, тогтоолын 2 дахь хэсгийн 2 дахь заалтын дагуу аймгийн түвшинд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, холбогдон гарах төсөв, зардлыг 2023, 2024 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах, Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. | 40,0 сая ОНТ | Тухайн онд газар зүйн нэрийн тодруулалт хийсэн сумын тоо | 13 | 2 | Аймгийн хэмжээнд 2 сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын даалгавар, төсөв төслийг ГЗБГЗЗГ-т хүргүүлэн батлуулсан. Баянжаргалан, Хулд сумдын “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил”-ын даалгаврын гүйцэтгэгч байгууллагаас үнийн санал авч гэрээ байгуулахаар ажиллаж байна. **Хэрэгжилт: ХБ** |
| 24 | Харьяалах нутаг дэвсгэрийг геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд зурагжуулах, геодези зураг зүйн газартай хамтран батлах, зардлыг 2023, 2024 оны орон нутгийн төсөвт тусган ажиллах. | | 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх төсвийн тооцоог гаргаж, 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулах саналыг оруулах | - | 1 | 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 эринд шилжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага, төсвийн тооцоо ГЗБГЗЗГ-аас батлагдсаны дараа 2024 оны орон нутгийн төсөвт тусгуулах саналыг хэлэлцүүлнэ. **Хэрэгжилт: ХБ** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | /тийм-1, үгүй-0/ | | | |
| **ДӨРӨВ: НИЙТИЙН АЖ АХУЙ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 25 | Аймгийнхаа ус, дулаан хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагууд, хувийн хэвшлийн ААН-үүдтэй хамтран гэр хорооллын айл, өрхүүдийг инженерийн дэд бүтцийн хангамжид холбох замаар 200-аас доошгүй өрхийн орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | - | Гэр хорооллын айл өрхүүдийн инженерийн дэд бүтцийн хангамжид холбогдсон өрхийн тоо | - | 200 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 10 айл өрх цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдож, 55 айлын 2 орон сууцны барилга гадна дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдохоор хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авсан барилгын угсралтын ажил нь үргэлжилж байна. **Хэрэгжилт: ХБ** |
| 26 | Шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшинд хамаарах инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулах. | - | Ашиглалтад орсон орон сууцны тоо Орон нутгийн өмчид шинээр бүртгэгдсэн түгээх сүлжээ у/м | 6 | 5 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар ашиглалтад орсон нийтийн зориулалттай 3 орон сууцны барилгын 42 м инженерийн түгээх сүлжээг орон нутгийн өмчид бүртгэж авах, шугам сүлжээний ашиглалтыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад хариуцуулах ажлыг зохион байгуулсан. **Хэрэгжилт: 60 хувь** |
| 27 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 17, 18, 19 дүгээр зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлэх. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 8, 17, 18, 19 дүгээр зүйлийн аймагт хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргаж 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэхээр хэрэгжилтийг нэгтгэж байна. **Хэрэгжилт: 80 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.2.7-д “Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж, “Сумдын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх. | 1,0 тэрбум УТ, 100.0 сая ОНТ | 1. Шинээр иж бүрэн инженерийн хангамжтай болсон сумдын тоо<br>2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулсан сумдын тоо<br>3. Шинээр төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон гэр хорооллын айл өрхийн тоо | 1.1<br>2.4<br>3.- | 1. 1<br>2. 5<br>3. 2 | 1. “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус суманд хэрэгжиж байгаа бөгөөд ажлын явц 30 хувьтай үргэлжилж байгаа. 2024 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>2. “Сумын хөгжил” төслийн хүрээнд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгуулан ажиллаж байна. Тус аймгийн Цагаандэлгэр сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах хөрөнгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөд тусгасан.<br>3. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 10 айл өрх цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдож, 55 айлын 2 орон сууцны барилга гадна дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдохоор хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авсан байна.<br>**Хэрэгжилт: 50 хувь** |
| 29 | Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж” | - | Захиалагчийн хяналтын тоо | 2 | 4 | “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” тус аймгийн Луус суманд 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд гүйцэтгэгч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, биелэлтийг гаргаж ирүүлэх | | | | | “Бурхант хясаат” ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж тус онд 50м3 цэвэрлэх байгууламжийн бетон цутгалтын ажил, био цөөрөм, гүний худаг, усан сангийн байгууламж, ус түгээх байрны ажлууд хийгдсэн. Ажлын явц 35 хувьтай, 2023 оны эхний хагас жилийн байдлаар бэлтгэл ажил хангагдаж ажлаа эхлүүлсэн. Тус онд БХБСайдын багцад 1,0 тэрбум төгрөг батлагдсан. Ажлын гүйцэтгэлийн 60 хувьд хүргэнэ. Дээрх ажилд захиалагчийн хяналт 4 удаа гүйцэтгэсэн бөгөөд тайланг БХТ-д хүргүүлэхээр ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 30 | Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын хүрээнд хийгдсэн “Ундны усны чанарын судалгааны нэгдсэн дүгнэлт, зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллах” | - | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | - | 80 | Дундговь-Ус ОНӨҮГ-аас Засгийн газрын 474 дүгээр тогтоолын дагуу нийт 80 ундны усны худагт чанарын шинжилгээг хийлгэсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 31 | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.11-д “Нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн засаг дарга шийдвэрлэх”-ээр заасан хуулийн заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах. | 85.0 сая ОНТ | Стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонгийн буурсан хувь | 0,79 | 1 | 2022 онд аймгийн төв болон 14 сумын төвийн хөрс бохирдуулагч нүхэн жорлон, угаадасны нүхний шинэчилсэн тооллого явуулж, 4557 нүхэн жорлон, угаадасны нүхний мэдээллийн сан үүсгэсэн. **Хэрэгжилт:50 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 32 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх | - | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар сольсон барилгын тоо | 9 | 3 | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил тус аймгийн 3 суманд хэрэгжсэн. Үүнд: Цагаандэлгэр сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Мөнхийн үргэлжлэл” ХХК гүйцэтгэж 2022 оны 11 дүгээр сард, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн ажлыг “Винтер гарден” ХХК гүйцэтгэж 9 болон 11 дүгээр сард тус тус ашиглалтад оруулсан. Дээрх төслийг хэрэгжүүлснээр 3 сумын нийт багш сурагчид ая тухтай орчинд сурч, боловсрох нөхцөл бүрдсэн. Мөн дараагийн ээлжид хамрагдах Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Өндөршил, Сайхан-Овоо Хулд зэрэг сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн зураг төслийг “Стийл прожект” ХХК-д боловсруулж магадлалаар баталгаажуулсан байна. **Хэрэгжилт: 50 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН 3388 нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд хэрэгжиж буй ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах. | - | Цэвэрлэх байгууламжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан эсэх (тийм-1 үгүй-0) | - | 1 | 1. Аймгийн төвийн хоногт 3000м3 хүчин чадалтай биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламж, гэр хорооллын 5,57 км бохир усны шугамын ажлыг “Сайн констракшн” ХХК гүйцэтгэж 2022 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан бөгөөд туршилт, тохируулгын ажил хийгдэж хэвийн ажиллаж байна.<br>2. Тус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын жилийн үйл ажиллагааны зардалд 2023 оны улсын төсвөөс 324.8 сая төгрөг төсөвлөхөөр шийдвэрлэгдсэн.<br>3. Цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг “Дундговь-Ус” ОНӨҮГ хариуцан ажиллаж байгаа бөгөөд ИТА 5, ээлжийн оператор 4, лаборант 1, химич 1, цахилгаанчин 1 нийт 12 ажилтантай ажиллаж байна.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 34 | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хүрээнд сумдын усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулж, Хууль зүйн яамны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлэх | - | Усны үйлчилгээний үнэ тарифыг батлуулсан сумын тоо | 1 | 3 | Тус аймгийн төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг “Дундговь-Ус” ОНӨҮГ нь 2012 онд батлагдсан, хууль зүйн яамны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлсэн үнэ тарифыг мөрдөж байна. Мөн ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдсон Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай сумд нь тус үнэ тарифыг мөрдөн ажилладаг. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 35 | “Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн газрын 2023 оны 209 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх | - | Ундны усны үйлчилгээний үнийн зөрүүг хөнгөлсөн эсэх (тийм-1 үгүй-0) | 0 | 1 | “Гэр хорооллын иргэдийн усны үйлчилгээний төлбөрийг хөнгөлөх тухай” Засгийн Газрын 2012 оны 209 дүгээр тогтоолыг аймагт хэрэгжүүлэхээр 2023 оны орон нутгийн төсөвт 76.0 сая төгрөгийг батлуулах хүсэлтийг хүргүүлсэн боловч батлагдаагүй. **Хэрэгжилт: ХБ** |
| 36 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, сумдад шинээр болон шилжиж хийгдэхээр тусгагдсан инженерийн хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт, үерийн хамгаалалтын далан, сувгийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг тайлагнах. | - | Инженерийн шугам сүлжээ хийгдсэн сумын тоо | 3 | 1 | 2023 оны улсын төсөвт Дэлгэрцогт сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын материалын үнийн зөрүү 419 сая төгрөг тусгагдсан бөгөөд гүйцэтгэгч “Алтайн үндэс констракшн” ХХК-д санхүүжилтийг олгосон. БХБС-ын 2023 оны багцад тус аймгийн Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын 1,0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд барилгын ажлыг 2023 оны 05 дугаар сард эхлүүлсэн, ажлын гүйцэтгэл 35 хувьтай үргэлжилж байна. Мөн Сайнцагаан сумын “Түмний хороолол”, “Хаус хороолол”-ын гадна бохир усны шугам, “Мандал хотхон”-ы гадна дулааны шугам сүлжээний өргөтгөлийн ажлууд он дамжин хэрэгжихээр бэлтгэл ажлууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангагдсан, гүйцэтгэгч “Ашид бьюлдинг” ХХК-д ажлыг эхлүүлэх чиглэл хүргүүлсэн. **Хэрэгжилт: ХБ** |
| 37 | Орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн байгууллагуудын зардал нөхөх төлөвлөгөөг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран боловсруулж, хэрэгжүүлэх. | - | Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | “Дундговь-Ус” ОНӨҮГ нь АХБ-ны төслийн дагуу санхүү эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор шалгаргасан “Сэцэнбилгүүн” ХХК-тай хамтран зөвлөн туслалцаатайгаар 2023-2028 оны зардал нөхөх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 38 | Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагыг төсөл, арга хэмжээ эхлэх үеэс тогтоох, хүлээлгэн өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах. | 600.0 сая Хувийн хэвшил | Мэргэжлийн байгууллагад хүлээлгэж өгсөн төсөл арга хэмжээний тоо | 2 | 1 | Эхний хагас жилийн байдлаар төсөл арга хэмжээ хэрэгжээгүй. **Хэрэгжилт: ХБ** |
| | | | Тавьсан хяналтын тоо | - | | |
| 39 | Инженерийн дэд бүтцийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрд гэр хорооллын 200-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах | 1,0 тэрбум УТ | Инженерийн хангамжид холбогдсон өрхийн тоо | - | 200 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар Сайнцагаан сумын хэмжээнд гэр хорооллын 10 айл өрх цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдож, 55 айлын 2 орон сууцны барилга гадна дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдохоор хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлийг авсан байна. **Хэрэгжилт: 30 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 40 | Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэл хийх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах. | - | Мэдээллийн санд оруулсан сумдын тоо | 14 | 15 | Инженерийн дэд бүтцийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2022 оны Орон нутгийн төсвийн 150,0 сая төгрөгөөр “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын мэдээллийг бүрдүүлсэн. 2023 онд аймгийн төвийн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн мэдээллийг бүрдүүлнэ. **Хэрэгжилт: ХБ** |
| 41 | Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд оруулж, мэдээллийн сангуудыг нэгтгэж, хамгаалалтын зурваст газар олгохгүй байх ажлыг зохион байгуулах. | - | Шинээр хамгаалалтын зурвас тогтоосныг мэдээллийн санд оруулсан эсэх (тийм-1, үгүй-0) | 1 | 1 | Аймгийн хэмжээнд 2219806 $м^2$ цэвэрлэх байгууламж, 25840.5м цахилгаан, 156766.8м холбооны, 31638м дулаан хангамжийн шугам, 64250м цэвэр усны шугам, 11545м урт бохир усны шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн санд оруулсан. Хамгаалалтын зурваст газар олголт хийгдээгүй болно. 2023 оны эхний хагас жилийн байдлаар ашиглалтад оруулсан инженерийн шугам сүлжээ байхгүй бөгөөд дээрх инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг мэдээллийн санд баяжилт хийгдээгүй байна. **Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 42 | Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийх | - | Төлөвлөгөөний тоо | - | 1 | “Нью грийн ворлд” ХХК –тай Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх 15.8 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. **Хэрэгжилт :80 хувь** |
| 43 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН 3713 төсөл”-ийн хүрээнд Төслийн удирдлага хэрэгжилтэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээний “Сэцэн билгүүн” ХК-ний боловсруулсан “Орон нутгийн өмчит нийтийн аж ахуйн байгууллагуудын зардал нөхөх төлөвлөгөөг аймгийн ЗДТГ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй хамтран баталж хэрэгжүүлэх | | | | | Дундговь-Ус” ОНӨҮГ нь АХБ-ны төслийн дагуу санхүү эдийн засгийг идэвхжүүлэх зорилгоор шалгарсан “Сэцэнбилгүүн” ХХК-тай хамтран зөвлөн туслалцаатайгаар 2023-2028 оны зардал нөхөх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 44 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН 3713 нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд Эрдэнэдалай сумын төвд шинээр ашиглалтад орсон ус хангамж, ариутгах татуургын системийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах | 105.5 сая ОНТ | Хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн эсэх (тийм-1, үгүй-0) | - | 1 | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Зүүн Өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН 3713 нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд 2022 онд тус аймгийн Эрдэнэдалай сумын төвд шинээр ашиглалтад орсон ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ашиглалт үйлчилгээг “Үлэмж хурд” ХХК хариуцан ажиллаж байна. Тус шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахад шаардагдах 105.5 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөрөнгөд батлуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| **Иргэдийг орон сууцжуулах чиглэлээр** | | | | | | |
| 45 | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн дэд бүтцийн ажил хийгдсэн, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хүрээнд орон сууцны хороолол барих боломжтой газруудыг орон нутгийн өмчид авч, орон сууцны хороолол барих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай хамтран ажиллах, санал боловсруулах холбогдох тооцоо, судалгааг боловсруулах, урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулах. | 100.0 сая ОНТ | Ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ТЭЗҮ-ийн тоо | - | 2 | Аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2,0 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулсан. Тус хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэхээр Сайнцагаан сумын 7 дугаар багт “Түмний хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Бес онцгой дизайн” ХХК гүйцэтгэж байна. **Хэрэгжилт: 50 хувь** |
| 46 | Улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх. Улирал бүр тус яаманд тайлан, мэдээлэл ирүүлэх. | - | Түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлсэн талаар тайлангийн тоо | 1 | 4 | Тус аймгийн хэмжээнд гадна инженерийн шугам сүлжээг улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн орон сууцны хороололд шинээр баригдах орон сууцны барилгын нийт талбайн 2 хувийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах замаар орон нутгийн өмчит түрээсийн орон сууцны сан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрдүүлэх хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлуулсан. Тус онд Сайнцагаан сумын 9 дүгээр багт хувийн хөрөнгө оруулалтаар 6 айлын инженерийн бүрэн хангамжтай түрээсийн байр баригдсан. **Хэрэгжилт: ХБ** |
| 47 | Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах бүтцийн нэгжийг байгуулж, орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан амины орон сууц барих бүсүүдийг тодорхойлж, эхний ээлжийн байршлыг нарийвчлан тогтоож, ИТХ-аар батлуулах. | - | ИТХ-аар батлуулсан төлөвлөгөөний тоо | - | 1 | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр батлагдсан Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Сайнцагаан сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай 8 га газрыг амины орон сууцны зориулалтаар төлөвлөж 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж аймгийн ИТХ-аар батлуулсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 48 | Гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын ашиглалтад тавих ерөнхий шаардлага MNS 6877:2020 стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах | - | Стандартын дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын тоо | 1052 | 250 | “Стийл лайн” ХХК-ийн боловсруулсан Сайнцагаан сумын Айраг багийн 9-р гудамжны тохижилтын зургийн дагуу MNS 6877:2020 стандартад нийцүүлэн дээрх гудамжны тохижилтын ажлыг хийгдэж байна. Энэ онд дэд бүтцийн тохижилтын ажлыг ОНХС-ийн 199,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Дундговь-Ус” ОНӨҮГ гүйцэтгэж байгаа бөгөөд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын явц 50 хувьтай үргэлжилж байна.<br>**Хэрэгжилт: 50 хувь** |
| 49 | Газар хөдлөлт болон галд тэсвэртэй, хөрсний бохирдолгүй, ариун цэврийн болон эрчим хүчний хэмнэлттэй норм, дүрэм, стандартын шаардлага хангасан, тухайн орон нутгийн цаг уур, бүс нутгийн онцлогт тохирсон, хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зургийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай хамтран боловсруулж батлуулан, иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах | - | Батлагдсан загвар зургаар үйлчлүүлсэн иргэдийн тоо | 5 | 3 | Хямд өртөг бүхий амины орон сууцны иж бүрэн нэг маягийн загвар зураг төслийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т боловсруулж магадлалаар баталгаажсан бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар уг зураг төслөөр үйлчилсэн иргэн байхгүй байна.<br>**Хэрэгжилт: ХБ** |
| **Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр** | | | | | | |
| 50 | Монгол Улсын Их хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалт “Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгуудыг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах”, паспортжуулахтай холбоотой багаж, тоног төхөөрөмж, | - | Паспортжуулсан барилгын тоо | 0 | 20 | “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 5 дахь заалтын хүрээнд аймгийн хэмжээнд ашиглагдаж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийтийн орон сууцны барилгын судалгааг гаргасан бөгөөд судалгаагаар ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн 2019 оноос хойш Сайнцагаан суманд сургууль, цэцэрлэгийн 4 барилгыг буулгаж дахин төлөвлөлтөд хамруулсан.<br>2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | техникээр хангах ажлыг зохион байгуулах | | | | | “Барилгын чанар, аюулгүй байдал-паспортжуулалт” сэдэвт салбар зөвлөгөөнд ГХБХБГ-ын 3 албан хаагч хамрагдаж барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааны дадлага ажилд оролцсон. Тус онд аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа насжилт өндөртэй сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлгийн барилгуудыг паспоржуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. **Хэрэгжилт: 30 хувь** |
| 51 | Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. Тухайлбал, барилгуудын “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-т “Барилгын дулаан хамгаалалтын норм”-ын шаардлагыг бүрэн хангасан байхаар болон “ногоон” барилгын үзэл баримтлалыг тусган хэрэгжүүлэх. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 0 | 1 | Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэр харгалзахгүйгээр бүх төрлийн барилга, байгууламжийн угсралт, засварын ажилд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж, барилгын норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2022 онд шинээр боловсруулагдаж батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНбД 31-25-22/, "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНбД 31-24-22/ барилын норм ба дүрмүүдийг сурталчилсан.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар орон сууц, олон нийтийн зориулалттай 10 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаврыг Засгийн газрын 2019 оны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” болон холбогдох норм дүрмийн дагуу боловсруулж захиалагчид хүргүүлсэн бөгөөд тус даалгаварт барилгын дулаан хамгаалалт болон эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч ашигласан байх талаар тусгаж, баталсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 52 | Ашиглагдаж байгаа олон нийт, иргэний болон үйлдвэрийн барилга байгууламжуудад шинэчилсэн байдлаар үзлэг, тооллого явуулах. | - | Үзлэгт хамрагдсан барилга байгууламжийн тоо | 70 | 75 | “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын төвийн барилга байгууламжид шинэчилсэн үзлэг, тооллого зохион байгуулж нийт 2393 барилга байгууламжийн мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. 2023 онд аймгийн төвд ашиглагдаж байгаа бүх барилга байгууламжийг бүртгэлжүүлж, мэдээллийн сан үүсгэнэ. **Хэрэгжилт: 30 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар 4 барилга байгууламж, 3 засвар тохижилтын ажилд “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу комисс ажиллаж, ашиглалтад оруулсан. Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/206 тоот албан бичгээр БХБЯ болон Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 54 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх. | - | Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилгын тоо | 29 | 20 | “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар 3 барилга байгууламж, 10 засвар тохижилтын ажилд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. Тайланг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/206 тоот албан бичгээр БХБЯ болон Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 65 хувь** |
| 55 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 353 дугаар | - | Барилга байгууламжийн ашиглалтын | 4 | 4 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар 7 барилга байгууламж, засвар, тохижилтын ажлыг “Барилга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх | | дүрэм-ийн хэрэгжилтийн тайлангийн тоо | | | байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу комисс ажиллаж, Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу гаргаж 2 дугаар улирлын тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/206 тоот албан бичгээр БХБЯ болон Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 56 | Барилга хот, байгуулалтын сайдын “Барилга, байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам батлах тухай” 2016 оны 180 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж ажиллах | - | Хувийн хэрэг хөтлөх журмыг хангуулж ажилласан эсэх (тийм-1, үгүй-0) | 1 | 1 | “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын төвийн нийт 2393 барилга байгууламжийн мэдээлэл бүртгэлжүүлж хувийн хэргийг цахимжуулсан. 2023 онд аймгийн төвийн ашиглагдаж буй бүх барилга байгууламжийн хувийн хэргийг цахимжуулахаар ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 57 | Барилга байгууламжийн хувийн хэргийг бүрэн цахимжуулж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх | - | Барилга, байгууламжийн хувийн хэргийг цахимжуулсан сумын тоо | 14 | 1 | “Дундговь аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлж, мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд аймгийн төвөөс бусад 14 сумын төвийн нийт 2393 барилга байгууламжийн хувийн хэргийг цахимжуулсан. Мөн энэ онд “Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын өгөгдөл, мэдээллийг бүрдүүлж мэдээллийн санд бүртгэх” зөвлөх үйлчилгээний тендерийн ажлыг зарлан аймгийн төвийн барилга байгууламжийн мэдээллийг бүрэн цахимжуулахаар ажиллаж байна. **Хэрэгжилт: ХБ** |
| 58 | Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.7 дахь заалтын дагуу барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг албадан буулгах арга хэмжээ авах, мэдээллийг БХБЯ-нд хүргүүлж ажиллах | - | Буулгасан барилгын тоо /шаардлага хангаагүй барилгын тоо/ | 2 | 1 | Аймгийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан барилгын судалгааг гаргасан. 2023 онд ашиглалтын шаардлага хангахгүй үйлчилгээний зориулалттай 1 барилгыг буулгаж, шинээр төлөвлүүлсэн. Албадан буулгасан барилга байхгүй болно. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 59 | Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй | - | “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ыг | 20 | 14 | Барилга угсралтын ажил явагдаж байгаа барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохдоо ХАБЭА-н инженертэй байх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны журам"-ын хэрэгжилтийг хангуулж ажиллах | | хангаж ажиллаж байгаа ААН ийн тоо | | | шаардлага тавьж угсралтын явцад захиалагчийн хяналт гүйцэтгэхдээ "Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам"-ыг /талбайн зохион байгуулалт, цэвэрлэгээ, хамгаалалтын хашаа, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ/ хэрхэн хангаж ажиллаж байгаад хяналт тавин ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар барилга угсралтын ажил эхэлсэн 7 барилга, 7 засварын ажилд тус журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 60 | Барилгын материалын лабораторийн итгэмжлэл, тоног төхөөрөмжийн хүчин чадал, ашиглалт, мэргэжилтэй боловсон хүчний ажилласан жил, шинжээчийн сургалтад хамрагдсан эсэх мэдээлэл, сорил шинжилгээний тоо хэмжээ, дүгнэлт бүхий тайланг ирүүлж ажиллах | - | Сорил шинжилгээний тоо | 18 | 20 | Хагас жилийн байдлаар сорилт шинжилгээ хийлгэх хүсэлт ирээгүй болно. **Хэрэгжилт: ХБ** |
| 61 | Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах | - | Нэмэгдсэн тоног төхөөрөмжийн тоо | - | 1 | Тус байгууллагын Барилгын материалын лаборатори нь 47 төрлийн тоног төхөөрөмжтэй бөгөөд 30 гаруй нэр төрлийн шинжилгээг хийх боломжтой. 2023 оны хагас жилийн байдлаар шинээр тоног төхөөрөмж худалдан аваагүй байна. **Хэрэгжилт: ХБ** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 62 | Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүчин чадал, ашиглалт, ажиллах хүчний мэдээлэл, үйлдвэрлэлийн борлуулалт, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх дэлгэрэнгүй судалгаа гаргах | - | Үйлдвэрлэлийн борлуулалт, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх гаргасан судалгааны тоо | 1 | 1 | Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, хүчин чадал болон үнийн судалгааг гарган мэдээллийн сантай болсон. Бүх ААН-үүдийг тусгай зөвшөөрөл, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг тохирлын гэрчилгээтэй болгох талаар шаардлага өгч хамтран ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 63 | Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн судалгаа гаргах, тухай оны эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргаж БХБЯ-нд хүргүүлэх. | - | Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн судалгаа гаргасан тоо | 2 | 2 | Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд илэрцийн байршлын судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэж, эрэлт нийлүүлэлтийн судалгааг гаргаж БХБЯ-нд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 64 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа элс, хайрга, дайргын карьерууд, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож, ашиглаж байгаа ААН-үүдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг Тохирлын үнэлгээнд хамруулан гэрчилгээжүүлэх шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах | - | Тохирлын үнэлгээнд хамрагдсан ААН-ийн тоо | 1 | 2 | Тус аймагт “Фриендли вей” ХХК, “Би Ай Ди И констракшн” ХХК-иуд бетоны дүүргэгч материал, бетон зуурмаг үйлдвэрлэж байна. Үүнээс “Фриендли вей” ХХК нь барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авч үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ тохирлын баталгаажуулалтад хамруулсан. **Хэрэгжилт: 50 хувь** |
| 65 | Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга | - | “Төрөөс барилгын салбарын талаар | - | 2 | Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний төлөвлөгөө”-нд аймгуудын Засаг дарга нарын хэрэгжүүлэх ажлуудын биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган БХБЯ-нд ирүүлэх | | баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний тайлангийн тоо | | | арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжүүлэх ажлын биелэлтийг гаргаж ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 3/218 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 50 хувь** |
| 66 | Барилгын салбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сарын аяны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг 05 дугаар сарын 15-ны дотор тайлагнах. Тухайн оны осол, гэмтлийн мэдээг өмнөх онтой харьцуулан гаргаж, дүгнэлт хийж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” сарын аяныг тус аймагт 2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 04 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан бөгөөд аяны хүрээнд аймгийн ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөлийн жилийн төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ХНХЯаманд хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувь.<br>Сарын аяны хүрээнд Сайнцагаан суманд улс, орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 4 барилгын угсралтын талбайд ХАБЭА-н үйл ажиллагааг хэрхэн хангаж ажиллаж байгаад үзлэг шалгалт хийж, тайлагнаж ажилласан. Аймгийн хэмжээнд 2023 он гарснаас хойш барилгын талбайд осол гэмтэл гараагүй байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 67 | Аймаг, нийслэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, барилгын салбарт хийж | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Аймгийн ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөлийн жилийн төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилгуудаас 2 барилгыг сонгон авч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал бүр тайлагнах. | | | | | ХАБЭА-н зөвлөл болон барилгын техникийн хяналт улсын байцаагчтай хамтран үзлэг шалгалт хийхээр төлөвлөгөөнд тусгаснаас Сайнцагаан суманд баригдаж буй усан бассейн бүхий спорт цогцолборын барилгад хяналт шалгалт хийж зөвлөмж өгч ажилласан. 640 суудалтай хүмүүнлэг сургуулийн барилга угсралтын ажил эхлээгүй байна. Эхний хагас жилийн тайланг аймгийн ЗДТГ-т нэгтгэн ХНХЯаманд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 68 | Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах. | - | MNS:ISO 21500 стандартыг аж ахуй нэгжүүдэд сурталчилсан тоо | 1 | 2 | Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй 12 аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчилж, стандартыг нэвтрүүлэх талаарх зөвлөмж хүргүүлсэн. **Хэрэгжилт: 50 хувь** |
| 69 | Батлагдсан нэг маягийн зураг төслийг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн БХТ-өөс авч хэрэглэх | - | Батлагдсан зураг төсвийг ашигласан тоо | 1 | 2 | Барилгын хөгжлийн төвд “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл” /100,160 ортой/, “Ерөнхий боловсролын дунд сургуулийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл” /320,640 суудалтай/, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан цэцэрлэг, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл” /цэцэрлэг-150, сургууль-320 хүүхдийн суудалтай, “Ерөнхий боловсролын бага сургуулийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл” /160 хүүхдийн суудалтай/, “Хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай барилгын нэг маягийн зураг төсөл” /50, 150, 200 хүүхдийн хүчин чадалтай/, Эрүүл мэндийн төв барилгын нэг маягийн зураг төсөл /10,15,22 ортой/, Соёлын төв барилгын нэг маягийн зураг төсөл /200,400 суудалтай/ нэг маягийн зураг, төсөл ашиглагдаж байна. Үүнээс 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Луус, Дэрэн, Өндөршил сумдад 10 ортой эрүүл мэндийн төвийн барилгын нэг маягийн зураг төслийг авч холболтын зураг хийлгэхээр ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 70 | Барилга байгууламжийн зураг төслийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан хугацааны дагуу боловсруулж, батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх | - | Баталсан Архитектур төлөвлөлтийн даалгаврын тоо | 22 | 20 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар 10 барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, 15 төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу боловсруулж, баталсан. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 71 | Төлөвлөж буй барилга байгууламжийн төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг холбогдох норм, | - | Боловсруулж батлуулсан | 4 | 4 | Тус онд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 15 төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дүрмийн дагуу боловсруулж, батлах, тайлан мэдээг улирал тутам ирүүлэх | | зургийн даалгаврын тоо | | | боловсруулж, батлуулан захиалагч байгууллагуудад хүргүүлсэн. Үүнээс 10 төсөл арга хэмжээ нь хэрэгжиж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 72 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Барилгын салбарын ажилтны зөвлөгөөн”-ийг жилд нэг удаа зохион байгуулж байх. | - | Зохион байгуулсан зөвлөгөөний тоо | 1 | 1 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Барилгын салбарын ажилтны зөвлөгөөн”-ийг 2023 оны 09 дүгээр сард Барилгачдын баярыг тохиолдуулан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. **Хэрэгжилт: ХБ** |
| **Статистик, мэдээллийн технологийн чиглэлээр** | | | | | | |
| 73 | Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2022 оны хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1) болон ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2022 оны хагас, бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-г заасан хугацаанд холбогдох газарт тайлагнах. | - | Тайлангийн тоо | 4 | 4 | Тус аймгийн хэмжээнд 2023 оны 2 дугаар улирлын байдлаар ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны барилгын мэдээллийг маягт А-ОС-1-ийн дагуу гаргаж ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 06-ний өдрийн 3/211 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд 60 айлын 3 орон сууцны барилга ашиглалтад орсон бөгөөд ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн болон амины зориулалттай орон сууц байхгүй байна. **Хэрэгжилт: 50 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 74 | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан “Барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулах ажлын хүрээнд барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулах мэдээлэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягт, “Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл” маягтын дагуу холбогдох мэдээг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлэх ажлыг зохион байгуулах | - | Гаргаж хүргүүлсэн тайлангийн тоо | 4 | 4 | 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 6 барилга байгууламж, 2 засварын ажлыг ашиглалтад оруулж, 12 барилга байгууламж, засварын ажилд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. Ашиглалтад орсон болон зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу 2 дугаар улирлын тайланг тус байгууллагын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/206 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 50 хувь** |
| 75 | Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаар хамтарсан “Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | - | Хамрагдсан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо | 13 | 4 | 2023 оны байдлаар тус аймагт барилга угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй 12, барилгын материал үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2, нийт 14 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 5 аж ахуйн нэгж байгууллага “Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар батлах тухай” тушаалын хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу бүртгэл үүсгэсэн байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| **Сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт, жендерийн тэгш байдал, ХБИ-ийн эрхийг хамгаалах чиглэлээр** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 76 | Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн цахим судалгааг явуулж, мэдээллийн сан бүрдүүлж, нэгдсэн системтэй холбох, ирээдүйд шаардлагатай ажлын байр, мэргэжлийг тодорхойлон БХБЯ-нд ирүүлэх | - | Мэдээллийн сан, Тайлангийн тоо | 1<br>2 | 1<br>2 | Мэргэжилтэй ажилчид, болон инженер техникийн ажилчдын судалгааг шинэчлэн гаргаж 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 1/359 тоот албан бичгээр БХТ-д хүргүүлсэн. Тус аймагт барилгын салбарт ХАБЭА, Барилгын материалын технологийн инженер, сантехник, цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуургын инженерүүд дутагдалтай байна<br>**Хэрэгжилт: 50 хувь** |
| 77 | Барилга, хот байгуулалтын салбарт Жендерийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах:<br>1. Салбарт зохистой хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрны талаарх ойлголт мэдлэгийг хүргэх, дэмжлэг үзүүлэх<br>2. Ялгаатай хэрэгцээг харгалзсан жендерийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагааг явуулан, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүйсээр ангилсан тоон мэдээлэл, үзүүлэлтүүдийг бүхий л үйл ажиллагааны хүрээнд тогтмол, бүрэн цуглуулах, нэгтгэх, түгээж ашиглах<br>3. Жендерийн мэдрэмжтэй салбарын болон хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг | - | Салбарын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90 | 100 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбарын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдолтой заалтуудын хэрэгжилтийг гаргаж 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 3/215 тоот албан бичгээр БХБЯаманд хүргүүлсэн.<br>Тус байгууллагын нийт албан хаагчдын дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Тус байгууллага нийт 26 албан хаагчтайгаас 12 эрэгтэй 14 эмэгтэй албан хаагч ажиллаж байна. “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг тус байгууллагын албан хаагчдын жендерийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх | | | | | “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 26 албан хаагч хамрагдсан.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |
| 78 | ХБ-тэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг орон нутагт хэрэгжүүлэх. Үүнд:<br>1. Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичиг “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 35-01-22/-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>2.Хуучин барилгуудад саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийж, гарсан үр дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажиллах<br>3. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлт, барилга байгууламжийн байнгын ашиглалтад авах, архитекторын даалгавар боловсруулалт зэрэг ажлуудад оролцуулах болон бусад ажлууд | - | -Сургалтад хамрагдан ажлын байраар хангагдсан ХБИ-ийн тоо<br>- Үзлэг, үнэлгээ хийсэн барилга байгууламжийн тоо<br>-ХБИ-ийн хэрэгцээнд нийцүүлэн засварласан барилгын тоо<br>- Барилга байгууламж ашиглалтад авах комисс, архитекторын даалгавар боловсруулахад оролцсон ХБИ-ийн тоо | - | 1<br>30<br>10<br>1 | ХБ-тэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг орон нутагт хэрэгжүүлсэн. Үүнд:<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар олон нийт, иргэний зориулалттай 10 барилгын архитектур төлөвлөлтийн даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй хүний орчны стандартыг тусгаж, батлуулсан.<br>БШУЯ-ны Тэгш хамруулах төслийн хүрээнд улсын төсвийн 195.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус аймгийн Сайнцагаан сумын ГИЦС-ийн хичээлийн Б байр, Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тэгш хүртэмжтэй болгон засварлуулсан.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар олон нийт, иргэний зориулалттай 5 барилгыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах байгууллагын төлөөллийг оролцуулсан.<br>**Хэрэгжилт: 100 хувь** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 79 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах, барилгын зураг төсөлд холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусган хэрэгжүүлэх, нийтийн зориулалттай барилга байгууламжуудын хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй эсэхэд нэгдсэн үзлэг хийж, орц, гарц болон дэд бүтцийг ХБИ-ийн эрх ашиг, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, үр дүнг тайлагнах зэрэг<br>ХБ-тэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг орон нутагт хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй 6 барилга байгууламж ашиглалтад оруулсан. Үүнээс АХБ-ны санхүүжилтээр аймгийн төвд баригдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга нь орон зай, төлөвлөлтийн хувьд олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан барилга болсон.<br>ХБ-тэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна.<br>**Хэрэгжилт: 80 хувь** |
| **Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр** | | | | | | |
| 80 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хүрээнд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхойлон, өмчлөлд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэн бүртгэх, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр ирүүлэх | - | Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад орсон барилга, байгууламжийн ашиглагч байгууллагыг тодорхойлон, өмчлөлд шилжүүлэх | 2 | 2 | 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад оруулсан Хулд сумын 10 ортой эрүүл мэндийн төвийн барилгыг ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлэхээр баримтын бүрдлийг хантан ажиллаж байна.<br>**Хэрэгжилт: ХБ** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудлыг шийдвэрлүүлэн бүртгэсэн тайлангийн тоо | | | |
| 81 | Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртгөөс Барилгын тухай хуульд заасны дагуу норм, нормативын санд шимтгэлийг төвлөрүүлэх, мэдээ тайлан улирал бүр ирүүлэх | - | Нормчлалын санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | 10 | 10 | Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртгөөс Барилгын тухай хуульд заасны дагуу норм, нормативын санд шимтгэлийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан 2023 оны эхний хагас жилийн байдлаар Барилгын хөгжлийн төвийн /Худалдаа хөгжлийн банкны/ 2600078533 тоот дансанд 5 аж ахуйн нэгж байгууллага 6,469,032 төгрөг төвлөрүүлсэн. Тайланг ГХБХБГ-ын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 3/213 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. **Хэрэгжилт: 70 хувь** |
| 82 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр ирүүлэх. | - | Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээ тайлангийн тоо | 12 | 12 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй эрх шилжүүлсэн 4, эрх шилжээгүй 8 нийт 12 төсөл арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийг мэдээллийг тухай бүрд Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системээр дамжуулан тайлагнаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| 83 | Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр баригдаж буй | - | Төсөл арга хэмжээний | 100 | 100 | БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “10 аймгийн төвийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мөн барихаар төлөвлөсөн барилга байгууламжийн гүйцэтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс талуудын харилцан уялдааг хангаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах | | гүйцэтгэлийн хувь | | | дулааны станц барих" төслийн хүрээнд хэрэгжиж буй тус аймгийн төвийн 20 Гккал хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажил 2022 онд эхэлсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулагчидтай 1 удаа уулзалт зохион байгуулж, төслийн нэгжтэй байнгын холбоотой ажиллаж байна. **Хэрэгжилт: 30 хувь** |
| 84 | Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаал /2022 онд хүргэгдсэн/-ын хэрэгжилтийг хангаан улс болон орон нутаг, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний захиалагчийн техник хяналтын зардлыг аймгийн ГХБХБГ-ын дансанд бүрэн төвлөрүүлж ажиллах | | Техник хяналтын зардлыг төвлөрүүлсэн гүйцэтгэлийн хувь | - | 100 | Улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний захиалагчийн техник хяналтын зардлыг аймгийн ГХБХБГ-ын дансанд тухай бүрт төвлөрүүлэн ажиллаж байна. **Хэрэгжилт: 100 хувь** |
| | **Дундаж хувь 100 хувь-37, 80 хувь – 3, 70 хувь-3, 66.6 хувь-1, 65 хувь-1, 60 хувь-1, 50 хувь-12, 55.3 хувь-1, 46 хувь-1, 44 хувь-1, 41.9 хувь-1, 30 хувь-4, ХБ-20** | | | | | **79,8 хувь** |

БАТАЛГААЖУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА Л.ДОРЖБАТ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХШҮХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ОДОНЧИМЭГ

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭСЭН:
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.УЯНГА